# ЗОРЧИГЧДЫН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

| | |
|---|---|
| Тендер шалгаруулалтын нэр: | ***ЗОРЧИГЧДЫН ХООЛ*** |
| Тендер шалгаруулалтын дугаар: | ***МИАТ/20240103128*** |

# I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

## А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

| | |
|---|---|
| **1. Тендерийн цар хүрээ** | 1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “**Хууль**” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон үйлчилгээ (цаашид “**үйлчилгээ**” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана. |
| | 1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана. |
| | 1.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгтэд заана. |
| **2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг** | 2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана. |
| **3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж** | 3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө. |
| **4. Худалдан авах ажиллагааны цахим систем** | 4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна. |
| **5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх** | 5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ. |
| | 5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, $20^1$, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна. |
| **6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага** | 6.1. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно. |

6.2. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3.Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.

6.4.Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5.Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

**7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага**

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

## Б.АГУУЛГА

**8. Тендер шалгаруулалтын баримт бичиг**

8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:
I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;
II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;
III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;
IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;
V Бүлэг. Тендерийн жишиг маягт;
VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2.Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер

| | |
|---|---|
| | бэлтгэнэ. |
| **9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах** | 9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын тавaас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.<br>9.2.Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.<br>9.3.Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.<br>9.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.<br>9.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө. |
| **10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт** | 10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.<br>10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.<br>10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно. |
| **11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах** | 11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.<br>11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.<br>11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын тавaас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана. |

## В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

| | |
|---|---|
| **12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл** | 12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.<br>12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйлчилгээ авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно. |

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

**13. Тендерийн иж бүрдэл**

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн үйлчилгээ үзүүлэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй үйлчилгээ ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан үйлчилгээ үзүүлэх төсөв;

13.2.8. ТШЗ-ны 21.5-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

**14. Тендерийн жишиг маягтууд**

14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн

маягтад бөглөж, илгээнэ.

**15. Хувилбарт санал**

15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

**16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг**

16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадлана. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

**17. Чадавхын болон туршлагын шаардлага**

17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

**17.3.** Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

| | |
|---|---|
| | 17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. |
| **18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт** | 18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна. |
| | 18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. |
| | 18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй. |
| | 18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй. |
| **19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт** | 19.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна. |
| | 19.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. |
| | 19.3. Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. |
| | 19.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна. |
| **20. Санал болгож буй үйлчилгээ шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг** | 20.1. Санал болгож буй үйлчилгээ нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ. |
| | 20.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ. |
| | 20.3. Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ. |
| **21. Тендерийн үнэ ба үнийн** | 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн |

| | |
|---|---|
| **хөнгөлөлт** | хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.<br>21.2. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.<br>21.3. Үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.<br>21.4. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.<br>21.5. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ. |
| **22. Тендерийн валют** | 22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана. |
| **23. Тендер хүчинтэй байх хугацаа** | 23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.<br>23.1. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.<br>23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.<br>23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана. |
| **24. Тендерийн баталгаа** | 24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана. |

24.2. Хуулийн 14.6-д зааснаар дараах тохиолдолд тендерийн баталгааг хуульд заасан хувь, хэмжээгээр улсын орлого болгоно. Үүнд:

24.2.1. ТШЗ-ны 23-т заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө өөрийн тендерээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзсан;

24.2.2. гэрээ байгуулах эрх авсан оролцогч гэрээ байгуулах, эсхүл гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй;

24.2.3. Захиалагчийн шийдвэртэй холбогдуулан Сангийн яаманд гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

24.3. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.4. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

## Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

**25. Тендер баталгаажуулах, илгээх**

25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн 07-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

**26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

## Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

| | |
|---|---|
| **27. Тендерийн талаар тодруулга авах** | 27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална. |
| **28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх** | 28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ. |
| **29. Тендерийг үнэлэх** | 29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйл, Сангийн сайдын “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын дагуу үнэлж, харьцуулна. |
| **30. Арифметик алдааг залруулах** | 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.<br>30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ. |
| **31. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт** | 31.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ. |
| **32. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох** | 32.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход дараах дараалльг баримтална:<br>32.1.1. ТШЗ-ны 21.1-д зааснаар санал болгосон тендерийн үнийг тогтоох;<br>32.1.2. ТШЗ-ны 21.3-д заасны дагуу санал болгосон үнийн хөнгөлөлт тооцох;<br>32.1.3. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааг залруулах;<br>32.1.4. ТШЗ-ны 29.1.1, 29.1.2, 29.1.3-т заасан үнийг шаардлагатай бол ТШЗ-ны 22.1-д заасан валютад хөрвүүлэх;<br>32.1.6. ТШЗ-ны 31.1-д заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж тооцох.<br>32.2. ТШЗ-ны 1.2-т заасны дагуу хоёр ба түүнээс дээш багцтай тендер шалгаруулалтад хэд хэдэн багцад хамтад нь хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерийг тодорхойлох, түүнд санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцохдоо дараах аргачлалыг баримтална:<br>32.2.1. багц тус бүрийн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгох;<br>32.2.2. хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерийн үнээс уг үнийн хөнгөлөлтийг тендер илгээх маягтад |

тодорхойлсон аргачлалын дагуу тооцсоны дараа шаардлагатай бол түүний харьцуулах үнийг дахин тодорхойлно. Ийнхүү тодорхойлохдоо хоёр ба түүнээс дээш багцад хамгийн бага харьцуулах үнэтэй тендер ирүүлсэн этгээд нь ТШЗ-ны 34-д зааснаар дахин магадлахад шаардлага хангаж байхыг шаардана;

32.2.3. дээрх үнэлгээг хийсний дараа тендерийн харьцуулах үнэд үндэслэн захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсхүл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, гэрээний үнийн нийлбэр нь хамгийн бага байх хувилбарыг сонгох.

32.3. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг хянан үзэж, үнэлнэ.

32.4. ТШЗ-ны 32.3-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.

**33. Тендерийг эрэмбэлэх**

33.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.

**34. Оролцогчийн чадавхыг дахин магадлах**

34.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан тохиолдолд дахин магадална.

34.2. ТШЗ-ны 34.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18.1-д заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19.1-д заасан техникийн чадавх, туршлага, гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.

34.3. Оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

## Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

**35. Мэдэгдэл хүргүүлэх**

35.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

**36. Гүйцэтгэлийн баталгаа**

36.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

36.2. Гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.

## II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

| | |
|---|---|
| **37. Урьдчилгаа төлбөр** | 37.1. Гэрээг хэрэгжүүлж эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгохгүй. |
| **38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах** | 38.1. Захиалагч VI бүлгийн гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ. |
| | 38.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална. |
| | 38.3. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ. |
| | 38.4. Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно. |
| **39. Тендер шалгаруулалтын гомдол** | 39.1. Хууль болон Сангийн сайдын баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын дагуу гомдлыг хянан шийдвэрлэнэ. |

| ТШЗ-ны холбогдох заалт | **А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ** |
|---|---|
| **ТШЗ 1.1** | Захиалагч: ***Монголын Иргэний Агаарын Тээвэр*** |
| **ТШЗ 1.1** | Тендер шалгаруулалтын нэр: ***Зорчигчдын хоол /кетеринг/*** |
| **ТШЗ 1.1** | Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: ***МИАТ/20240103128*** |
| **ТШЗ 1.2** | Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: |
| **ТШЗ 1.3** | Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: ***“Үгүй”*** |
| **ТШЗ 2.1** | Санхүүжилтийн эх үүсвэр нь: ***Өөрийн хөрөнгөөр*** |
| **ТШЗ 2.1** | Нийт төсөвт өртөг: ***16,597,655,500 /арван зургаан тэрбум таван зуун ерэн долоон сая зургаан зуун тавин таван мянга таван зуу/ төгрөг*** |
| **Б.АГУУЛГА** | |
| **ТШЗ 9.1** | Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг:<br><br>Хүлээн авагчийн нэр: ***Хангамжийн хэлтсийн мэргэжилтэн О.Баярмаа*** Хаяг: ***МИАТ ТӨХК, ХУД 21-р хороо Буянт Ухаа дахь МИАТ ТӨХК-ийн 2-р байр, Хангамжийн хэлтэс 117 тоот***<br><br>Утасны дугаар: ***70049860***<br><br>Цахим шуудангийн хаяг: ***bayarmaa.oy@miat.com***<br><br>Тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр албан бичгээр гаргаж, түүний хуулбарыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д нийтлэх бөгөөд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Иймд тендерт оролцохыг сонирхогч этгээдүүд дээрх цахим систем дэх тендерийн урилгын тодруулга, мэдээллийг байнга шалгахыг зөвлөж байна. Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5 хоногоос багагүй байна. |
| **ТШЗ 10.1** | Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: ***“Үгүй”***<br><br>Жич : Ажлын талбайтай ажлын өдрийн 09:00-16:00 цагийн хооронд танилцаж болно.<br><br>***МИАТ ТӨХК, ХУД 21-р хороо Буянт Ухаа дахь МИАТ ТӨХК-ийн байр*** |

| В. ТЕНДЕР БЭЛТГЭХ | |
|---|---|
| **ТШЗ 12.1** | Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл. ***“Монгол хэл” дээр байна.*** |
| **ТШЗ 15.1** | Хувилбарт санал ирүүлэхийг: ***“Зөвшөөрөхгүй”*** |
| **ТШЗ 16.1.2** | Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: ***“Шаардана”***<br>- ***Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай. Татварын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй, “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” www.tender.gov.mn болон “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана.***<br>- ***Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолтыг “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” www.tender.gov.mn болон “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана.***<br>- ***Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлнэ.*** |
| **ТШЗ 18.1** | Санхүүгийн чадавхын шаардлага: ***“Шаардана”***<br>1. ***Гэрээний үүргийн биелэлтийг хангах түргэн хөрвөх чадвартай хөрөнгө эсхүл авах боломжтой зээлийн хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 15 хувиас багагүй байх.*** /Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тус тус тодорхойлно/<br>Үүнд:<br>• Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны/<br>• Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт ирүүлнэ.<br>• Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд;<br>2. ***Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 3 жилийн аль нэг жилд гүйцэтгэсэн борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсвийн 20 хувиас багагүй байх. /2021, 2022,2023/*** |
| **ТШЗ 18.2** | Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг: |

| | |
|---|---|
| | ***1. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдийн лавлагаа;***<br>***2. Сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайлан /Цахим системээр дамжуулан шалгана/2021, 2022,2023/*** |
| **ТШЗ 19.1** | Техникийн чадавх болон туршлагын шаардлага: ***"Шаардана"***<br><br>Үйлчилгээ үзүүлэх хүний нөөц: ***"Шаардана"***<br><br>Үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: ***"Шаардана"***<br><br>Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: ***"Шаардана"***<br><br>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: ***"Шаардана"***<br><br>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: ***"Шаардана"*** |
| **ТШЗ 19.2** | Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:<br><br>***Шаардсан хүний нөөцийн мэдээллийг V бүлгийн маягтын дагуу ирүүлэх;***<br><br>**1.** Хоол үйлдвэрлэлийн технологичийн ур чадварын шаардлага: **Хоол үйлдвэрлэлийн чиглэлээр бакалаврын зэрэгтэй байна.** /ТББ-т хавсарган ирүүлнэ/<br>1.1 Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, /Мэргэжлээрээ ажилласан хугацааг ажлын газрын тодорхойлолтыг ТББ-т хавсарган ирүүлнэ/<br>1.2 Мөн тухайн тендерт оролцогч компанид сүүлийн нэг жил ажилласан байх, /E-mongolia цахим системээс нийгмийн даатгалын лавлагааг ТББ-т хавсарган ирүүлнэ/<br>2. Ерөнхий тогоочид тавигдах шаардлага:<br>**Хоол үйлдвэрлэлийн чиглэлээр бакалаврын зэрэгтэй байна.** /ТББ-т хавсарган ирүүлнэ/<br>2.1 Салбартаа 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, /Мэргэжлээрээ ажилласан хугацааг ажлын газрын тодорхойлолтыг ТББ-т хавсарган ирүүлнэ /<br>2.2 Мөн тухайн тендерт оролцогч компанид сүүлийн нэг жил ажилласан байх, /E-mongolia цахим системээс нийгмийн даатгалын лавлагааг ТББ-т хавсарган ирүүлнэ/<br>3. Эрүүл ахуйчид тавигдах шаардлага:<br>Эрүүл мэндийн сайдын 2018.04.16-ны өдрийн А/142 тушаалын дагуу Эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтаныг томилсон байх. |

| | |
|---|---|
| | 3.1 Эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтанаар 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, /Мэргэжлээрээ ажилласан хугацааг ажлын газрын тодорхойлолтыг ТББ-т хавсарган ирүүлнэ/<br>3.2 Мөн тухайн тендерт оролцогч компанид сүүлийн нэг жил ажилласан байх, /E-mongolia цахим системээс нийгмийн даатгалын лавлагааг ТББ-т хавсарган ирүүлнэ/<br>4. Хоол зүйчид тавигдах шаардлага:<br>Хоол зүйчийн мэргэжилтэй байх,<br>4.1 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, / Мэргэжлээрээ ажилласан хугацааг ажлын газрын тодорхойлолтыг ТББ-т хавсарган ирүүлнэ /<br>4.2 Мөн тухайн тендерт оролцогч компанид сүүлийн нэг жил ажилласан байх, /E-mongolia цахим системээс нийгмийн даатгалын лавлагааг ТББ-т хавсарган ирүүлнэ/<br><br>***Үйлчилгээ үзүүлсэн ижил төстэй /нийтийн хоолны үйлчилгээ/ гэрээний талаар V бүлгийн маягтын дагуу бэлтгэсэн мэдээлэл ирүүлэх;***<br><br>Сүүлийн 3 жилийн /2021, 2022, 2023/ аль нэг жилд батлагдсан төсөвт өртгийн 10 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй үйлчилгээ гүйцэтгэсэн доод тал нь нэг гэрээний мэдээлэл ирүүлнэ. Үүнд:<br><br>Гэрээний хуулбар гэрээ дүгнэсэн актыг Е-баримтын хамт; хугацаа дуусаагүй гэрээний хувьд захиалагч байгууллагын тодорхойлолт, Е-баримтын хамт ирүүлнэ. /Нийт гэрээний нийлбэр дүнгээр тооцно/<br><br>***Үйлчилгээ үзүүлэхэд ашиглахаар заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл ирүүлэх***<br><br>1. Чингис хаан ОУНБ-ын аюулгүй байдал хамгаалалтын бүсэд хоол үйлдвэрлэл гүйцэтгэхэд шаардлагатай өөрийн эсхүл түрээсийн байртай байна. /байхгүй тохиолдолд МИАТ ТӨХК-ийн Кэтерингийн зориулалттай объектыг түрээслэн ашиглах боломжтой. Объектын мэдээллийг www.tender.gov.mn сайтад холбогдох тендерийн ТЭЗҮ хэсэгт байршуулсан тул танилцах боломжтой/.<br>2. Тендерт оролцогч нь өөрийн тоног төхөөрөмжтэй байна.<br>3. Тендерт шалгарсан компани Захиалагч талын тусгай зориулалтын автомашиныг түрээсийн гэрээгээр авч ашиглана. /Хэрэв МИАТ ТӨХК-ийн кэтерингийн зориулалттай объектыг түрээслэн ашиглах тохиолдолд МИАТ ТӨХК-ийн Кэтерингийн зориулалттай объектоос Чингис хаан ОУНБ аюулгүй байдал хамгаалалтын бүс хүртэлх тээвэрлэлт, дамжуулан ачилт, буулгалт тэдгээрийн аюулгүй байдлыг ханган ажиллана, холбогдох даатгалыг хариуцах/<br>Түрээсийн нөхцөл: Тусгай зориулалтын автомашинаар **нэг удаагийн** нислэгт кэтеринг үйлчилгээ хүргэх түрээсийн зардал 45,000 төгрөг байна.<br>Тус түрээсийн зардалд: 5 километрийн шатахууны зардал, автомашины агаарын хөлөгт үйлчлэх мот/цаг болон жолоочийн хөлс тус тус багтсан. |

| | |
|---|---|
| | Замын маршрут: Чингис хаан ОУНБ-д байрлах газрын үйлчилгээний автозогсоолоос кaтеринг үйлчилгээгээр тусгай зориулалтын автомашиныг цэнэглэсний дараа нислэгийн талбай буюу перрон (тусгай талбай) хүрээд агаарын хөлгийн R3 хаалган дээр подьёмыг (ачаа өргөгч) өргөж буулган бизнес зорчигчийн катеринг үйлчилгээ, L2 хаалган дээр үлдэгдэл катеринг үйлчилгээг нийлүүлээд буцаж автозогсоол хүрэх. Тендерт шалгарсан оролцогч нь МИАТ ТӨХК-ийн эзэмшлийн тусгай зориулалтын автомашиныг түрээслэхдээ катеринг үйлчилгээгээ өөрийн зардлаар нисэх буудлын хамгаалагдсан бүс рүү агаарын хөлөг хөөрөхөөс 2 цагийн өмнө хүргэж өгнө. Учир нь гаалийн болон аюулгүй байдал, хамгаалалтын албаны хяналт шалгалтаар дамжуулж Тусгай зориулалтын автомашинд ачилт хийнэ. /Тусгай зориулалтын автомашины техникийн тодорхойлолтыг ТЭЗҮ хэсэгт хавсаргав/. Хэрэв тендерт оролцогч компани тусгай зориулалтын автомашинтай бол тус заалт хамаарахгүй.<br>4. Өөрийн эсхүл гэрээт хүнсний микробиологийн магадлан итгэмжлэгдсэн лабораторитой байна. Лабораторийн гэрчилгээний хуулбар, хэрэв гэрээт бол гэрээний хамт ирүүлнэ.<br>5. Тендерт оролцогч өөрийн байранд үйл ажиллагаа явуулах тохиолдолд катерингийн үйлчилгээнд дагалдах ус, ундаа, нэг удаагийн хэрэгсэл болон бусад бараа бүтээгдэхүүнийг хадгалах 500 мкв-аас багагүй стандартын шаардлага хангасан төрөлжсөн агуулахтай байна. /МИАТ ТӨХК-ийн катерингийн байрыг түрээслэх тохиолдолд тус заалт хамаарахгүй/<br><br>***Катерингийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг болохыг нотлох Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан цахимаар шалгана.*** |
| **ТШЗ 19.3** | Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: ***“Шаардахгүй”*** |
| **ТШЗ 21.4** | Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: ***“Тохируулахгүй тогтмол байна”*** |
| **ТШЗ 24.1** | Тендерийн баталгааны дүн: ***82,988,278 /наян хоёр сая есөн зуун наян найман мянга хоёр зуун далан найм/ төгрөг*** |
| **Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ** | |
| **ТШЗ 25.5** | Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: |
| **ТШЗ 26.1** | Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:<br>Огноо: ***2024 оны 07 дугаар сарын 31-ний өдөр***<br>Цаг: ***09 цаг 00 минут*** |

| | |
|---|---|
| **ТШЗ 26.2** | Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.<br>Огноо: ***2024 оны 07 дугаар сарын 31-ний өдөр***<br>Цаг: ***09 цаг 30 минут***<br>Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: ***МИАТ ТӨХК, ХУД 21-р хороо Буянт Ухаа дахь МИАТ ТӨХК-ийн 2-р байр, 117 тоот*** |
| **Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ** | |
| **ТШЗ 31.1** | Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: ***“Үгүй”*** |
| **Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ** | |
| **ТШЗ 36.1** | Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: ***“Тийм”*** |

## III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Кейтерингийн компани нь МИАТ ТӨХК-ийн Улаанбаатараас эхлэлтэй гадаад болон дотоодын нислэгт кейтерингийн үйлчилгээ үзүүлнэ. Ингэхдээ нислэгт зориулж төвлөрсөн гал тогоонд үйлдвэрлэсэн хоолыг агаарын хөлгийн хаалганд МИАТ ТӨХК-ийн ажилтанд хүлээлгэн өгөх хүртэлх бүх үйл ажиллагааг Монгол Улс болон олон улсад мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэх үүрэгтэй. Тухайлбал, хүнсний болон агаарын тээврийн аюулгүй үйл ажиллагааг бие даан хариуцах чадамжтай байх ёстой.

<table>
<tr><td></td><td colspan="8">Бизнес ангиллын хоолны техникийн тодорхойлолт</td></tr>
<tr><td>1.</td><td colspan="4">Халуун өглөөний цай /cycle 1/<br>*Жин заасан хэмжээнээс багагүй байх<br></td><td colspan="4">Халуун өглөөний цай /cycle 2/<br>*Жин заасан хэмжээнээс багагүй байх<br></td></tr>
<tr><td></td><td>Нэр төрөл</td><td>Жин</td><td>Харагдах байдал</td><td>Зураг</td><td>Нэр төрөл</td><td>Жин</td><td>Харагдах байдал</td><td>Зураг</td></tr>
<tr><td>1.1</td><td colspan="8">Зууш</td></tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.1.1** | **Яргай загасны зууш**<br>- Яргай загас 50 гр<br>- Өргөст хэмх<br>- Ногоон сонгино<br>- Олон үрийн талх<br>- Өндөг<br>- Лимон<br>- Бри бяслаг | 73 гр | Зурагт үзүүлснээр |  | **Үхрийн хэлэн зууш**<br>- Үхрийн хэл 50гр<br>- Мөөг<br>- Салат навч, рокет навч<br>- Пармезан бяслаг<br>- Цөцгийн тос<br>- Сармис | 70 гр | Зурагт үзүүлснээр |  |
| **1.2** | **Амттан** | | | | | | | |
| **1.2.1** | **Жимсний цуглуулга**<br><br>- Луу жимс<br>- Жүрж<br>- Киви<br>- 2 төрлийн усан үзэм<br>- Тарвас | 64 гр | Зурагт үзүүлснээр |  | **Жимсний цуглуулга**<br><br>- Аньс,<br>- Нэрс,<br>- Чацаргана<br>- Өрөл | 65 гр | Зурагт үзүүлснээр |  |
| **1.3** | **Үндсэн хоол** | | | | | | | |
| 1.3.1 | Жигнэсэн банш /50%/<br>- Дээд гурил<br>- Үхрийн мах<br>- Сонгино<br>- Лууван<br>- Ногоон хулуу<br>- Бууцай<br>- Цөцгий<br>- Улаан лооль | 240 гр | |  | Тахианы махан ороомог – /50%/<br><br>- Ногооны хавчуургатай тахианы гуяны цул мах – 130 гр<br>- Амталсан будааны хачиртай | 280 гр | |  |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | */10 ширхэгээс багагүй/*<br>*Цөцгий* | | | | - Ногоон хулуу<br>- Улаан лооль<br>- Эрдэнэшиш<br>- Хар перец<br>- Гич<br>- Крем соус<br>- Брокколи | | | |
| 1.3.2 | Омелетте шарсан зайдас /50%/<br>- Өндөг 2 ш<br>- Зайдас–100гр<br>- Бууцай<br>- Улаан лооль<br>- Моцарелла<br>- Ургамлын тос | 225 гр | |  | Шарсан банш, цөцгийтэй */10 ширхэг/*<br>- Дээд гурил<br>- Үхрийн мах<br>- Сонгино<br>- Лууван<br>- Ногоон хулуу<br>- Бууцай<br>- Цөцгий<br>- Улаан лооль<br>- Цөцгийтэй<br><br>*/10 ширхэгээс багагүй/* | 240 гр /50%/ | |  |
| **1.4** | **Талх** | | | | | | | |
| 1.4.1 | Кроссант<br>Хулууны үртэй талх<br>Гүнждийн үртэй хар талх | Тус бүр 1 ш | | | Кроссант<br>Хулууны үртэй талх<br>Гэрийн боорцог – 2 ш | Тус бүр 1 ш | | |
| 1.4.2 | Жимсний чанамал | 28 гр 1 ш | |  | Жимсний чанамал | 28 гр 1 ш | |  |
| | Зөгийн бал | 28 гр 1 ш | | | Зөгийн бал | 28 гр 1 ш | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | |   | | | |   |
| 1.4.3 | Йогурт | 100 гр | |   | Йогурт | 100 гр | |   |
| | Масло | 10 гр | Зурагт үзүүлснээр |  | Масло | 10 гр | Зурагт үзүүлснээр |  |
| **2.** | **Өдрийн хоол /cycle 1/**  ***Жин заасан хэмжээнээс багагүй байх** | | | | **Өдрийн хоол /cycle 2/**  ***Жин заасан хэмжээнээс багагүй байх** | | | |
| **2.1** | **Зууш** | | | | | | | |
| 2.1.1 | Үхрийн хэлэн зууш | 80 гр | Зурагт үзүүлснээр |  | Грек салат | 70 гр | Зурагт үзүүлснээр |  |
| **2.2** | **Амттан** | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.1 | **Жимсний цуглуулга**<br><br>- Луу жимс<br>- Жүрж<br>- Киви<br>- 2 төрлийн усан үзэм<br>- Тарвас | 64 гр | Зурагт үзүүлснээр |  | **Үзэмтэй хайлмаг**<br><br>- Дээд гурил<br>- Бор үзэм<br>- Бор элсэн чихэр<br><br>*/шар тосыг шүүж, царцаасан байна/* | 65 гр | Зурагт үзүүлснээр<br><br>Дессертны аяганд дундаас дээш хэмжээгээр савлаж, гадуур нь хүсний скочоор битүүмжилсэн байна. |  |
| **2.3** | **Үндсэн хоол** | | | | | | | |
| 2.3.1 | Үхрийн гол махан стейк /40%/<br>- Үхрийн гол мах 150 гр<br>- Шарсан төмс<br>- Брокколи<br>- Цагаан цэцэгт байцаа<br>- Вандуй бөөрөнхий<br>- Улаан лооль<br>- Темпура гурил<br>- Сонгино<br>- Давс | 240 гр | Зурагт үзүүлснээр |  | Тахианы махан ороомог /30%/<br><br>- Тахианы гуяны цул мах 130гр<br>- Лууван<br>- Бууцай<br>- Амтат төмс<br>- Будаа<br>- Юуцай<br>- Ногоон хулуу<br>- Эрдэнэшиш<br>- Хар перец<br>- Яншуй<br>- Гич<br>- Крем соус<br>- Давс | 240 гр, 4 ш | Зурагт үзүүлснээр |  |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3.2 | Хуушуур /30%/<br><br>- Гурил<br>- Үхрийн татсан мах<br>- Хар перец<br>- Сонгино<br>- Давс<br><br>*/брокколи, байцааны салат, улаан лоолийн хачиртай/* | 260 гр, 4 ш | Зурагт үзүүлсний дагуу хэлбэрээр савласан байна. |  | Үхрийн махан шорлог /40%/<br><br>- Үхрийн цул мах 180гр<br>- Нухсан төмс<br>- Улаан лооль<br><br>*/амталгаа: давс, перец, соё соус, гүнжидийн тос, гүнждийн үр, цөцгийн тос/* | 275 гр | Зурагт үзүүлсний дагуу ногооны хачиртай байх ба шорноос салгаж зориулалтын тавганд савласан байна. |  |
| 2.3.3 | Яргай загас /30%/<br>- Яргай загасны мах 130гр<br>- Нухсан төмс<br>- Брокколи<br>- Цагаан цэцэгт байцаа<br>- Давс<br>- Вандуй<br>- Улаан лооль<br>- Лууван<br>- Моцарелла<br>- Сүү, крем соус<br>- Лимон | 250 гр | Зурагт үзүүлснээр |  | Бууз /30%/<br><br>- Гурил<br>- Үхрийн мах<br>- Сонгино<br>- Хар перец<br>- Ногооны хачиртай<br>- Давс<br><br>*/Тус бүр 40 гр-аас багагүй 5 ш/* | 260 гр, 5 ш | Зурагт үзүүлсэн хэлбэрээр чимхсэн байх ба зориулалтын тавганд савласан байна. |  |
| **2.4** | **Талх** | | | | | | | |
| 2.4.1 | Кроссант<br>Хулууны үртэй талх | Тус бүр 1 ш | | | Кроссант<br>Хулууны үртэй талх | Тус бүр 1 ш | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Гүнждийн үртэй хар талх | | | | Гүнждийн үртэй хар талх | | | |
| 2.4.2 | Жимсний чанамал | 28 гр 1 ш | |  | Жимсний чанамал | 28 гр 1 ш | |  |
| | Зөгийн бал | 28 гр 1 ш | |  | Зөгийн бал | 28 гр 1 ш | |  |
| | Масло | 8 гр | |  | Масло | 8 гр 1 ш | |  |

<table>
<tr><td></td><td colspan="8">Энгийн ангиллын хоолны техникийн тодорхойлолт</td></tr>
<tr><td>1</td><td colspan="4">Хүйтэн зууш/сендвич /cycle 1/<br><br>*Жин заасан хэмжээнээс багагүй байх.</td><td colspan="4">Хүйтэн зууш/сендвич /cycle 2/<br><br>*Жин заасан хэмжээнээс багагүй байх.</td></tr>
<tr><td></td><td>Нэр төрөл</td><td>Хэмжээ</td><td>Харагдах байдал</td><td>Зураг</td><td>Нэр төрөл</td><td>Хэмжээ</td><td>Харагдах байдал</td><td>Зураг</td></tr>
<tr><td>1.1</td><td colspan="8">Үндсэн хоол</td></tr>
</table>

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.1 | Үхрийн махтай сендвич /100%/<br>- Багет талх<br>- Зорж хэрчсэн үхрийн өвчүүний мах 100гр<br>- Өргөст хэмх<br>- Улаан лооль<br>- Оистер соус<br>- Гүнжлийн тос<br>- Хуудсан бяслаг<br>- Айсберг<br>- Давс<br>- Бууцай<br>- Кетчуп зөгийн бал<br>- Майонез | 280 гр | |  | Тахианы махтай сендвич<br>/100%/<br>- Багет талх<br>- Тахианы цээж мах 100гр<br>- Өргөст хэмх<br>- Улаан лооль<br>- Оистер соус<br>- Гүнжлийн тос<br>- Хуудсан бяслаг<br>- Айсберг<br>- Давё<br>- Бууцай<br>- Кетчуп зөгийн бал<br>- Майонез | 280 гр | |  |
| | **Амттан** | | | | | | | | |
| 1.1.2 | Хатаасан жимсний цуглуулга<br>- Хасарваань<br>- Хар чавга<br>- Чангаанз<br>- Цангис<br>- Үзэм | 1 ш<br>30-50 гр | Үйлдвэрийн битүүмжилсэн гялгар савлагаатай байна. |  | Хатаасан жимсний цуглуулга<br>- Хасарваань<br>- Хар чавга<br>- Чангаанз<br>- Цангис<br>- Үзэм | 1ш<br>30-50 гр | Үйлдвэрийн битүүмжилсэн гялгар савлагаатай байна. |  |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.3 | Йогурт | 1 ш<br>100 гр | Үйлдвэрийн савлагаатай байна. |  | Йогурт | 1 ш<br>100 гр | Үйлдвэрийн савлагаатай байна. |  |

<table>
<tr><td></td><td colspan="8">Энгийн ангиллын хоолны техникийн тодорхойлолт</td></tr>
<tr><td>2</td><td colspan="4">Халуун хоол /cycle 1/<br><br>*Жин заасан хэмжээнээс багагүй байх</td><td colspan="4">Халуун хоол /cycle 2/<br><br>*Жин заасан хэмжээнээс байх</td></tr>
<tr><td></td><td>Нэр төрөл</td><td>Хэмжээ</td><td>Харагдах байдал</td><td>Зураг</td><td>Нэр төрөл</td><td>Хэмжээ</td><td>Харагдах байдал</td><td>Зураг</td></tr>
<tr><td>2.1</td><td colspan="8">Үндсэн хоол</td></tr>
<tr><td>2.1.1</td><td>Үхрийн махан гуляш /60%/<br>- Үхрийн мах 150гр<br>- Брокколи<br>- Төмс<br>- Улаан лооль<br>- Давс<br>- Цөцгийн тос<br>- Демигласс<br>- Нухсан төмс</td><td>280 гр</td><td>Зурагт үзүүлснээр</td><td></td><td>Үхрийн махан хуурга 60%<br>- Үхрийн мах 150гр<br>- Брокколи<br>- Төмс<br>- Улаан лооль<br>- Давс<br>- Цөцгийн тос<br>- Демигласс<br>- Будаа</td><td>280 гр</td><td></td><td></td></tr>
</table>

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.2 | Гриллдэж шарсан тахианы мах /40%/<br>- Тахианы гуяны цул мах 130 гр<br>- Будаа<br>- Лууван<br>- Юуцай<br>- Гүнждийн үр<br>- Давч<br>- Кажун<br>- Курицы<br>- Гич<br>- Цөцгийн тос | 260 гр | |  | Терияки тахиа<br>/40%/<br>- Тахианы гуяны цул мах 130 гр<br>- Будаа<br>- Лууван<br>- Юуцай<br>- Бууцай<br>- Амтат төмс<br>- Ногоон хулуу<br>- Яншуй<br>- Ургамлын тос<br>- Хар перец<br>- Гич<br>- Курица<br>- Крем | 260 гр | |  |
| **2.2** | **Салат** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.1 | Грек салад | 80 гр | Зурагт үзүүлсний дагуу савласан, бяслагтай грек салад байна. |  | Грек салад | 80 гр | Зурагт үзүүлсний дагуу савласан, бяслагтай грек салад байна. |  |
| **2.3** | **Амттан** | | | | | | | |
| 2.3.1 | Жимсний цуглуулга<br>- Улаан, ногоон усан үзэм<br>- Луу жимс<br>- Жүрж | 60 гр | Дессертны аяганд 60 хувийн дүүргэлттэй савласан байна. |  | Бяслагтай бялуу эсхүл өндөгтэй тарт /cheesecake or egg tart/<br>- зөөлөн бяслаг<br>- элсэн чихэр<br>- сүүн крем<br>- өндөг<br>- ванилийн охь<br>- цөцгийн тос | 70 гр | Зориулалтын тавганд савласан байна. |  |
| **2.4** | **Талх** | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.4.1 | Булочка | 1 ш | Үйлдвэрийн битүүмж савлагаатай |  | Хулууны үртэй талх | 1 ш | Үйлдвэрийн битүүмж савлагаатай |  |
| 2.4.2 | Масло /8 гр-аас багагүй/ | 1 ш | Нэг удаагийн зориулалттай үйлдвэрийн савлагаатай байна. |  | Масло /8 гр-аас багагүй/ | 1 ш | Нэг удаагийн зориулалттай үйлдвэрийн савлагаатай байна. |  |
| 2.4.3 | Жимсний чанамал | 1 ш<br>20 гр | |  | Жимсний чанамал | 1 ш<br>20 гр | |  |

| | Нисэх бүрэлдэхүүний хоолны техникийн тодорхойлолт | | | |
|---|---|---|---|---|
| **1** | **Хүйтэн зууш /cycle 1/**<br>*Жинг заасан хэмжээнээс багагүй гэж ойлгоно. | | **Хүйтэн зууш /cycle 2/**<br>*Жинг заасан хэмжээнээс багагүй гэж ойлгоно. | |
| | **Нэр төрөл** | **Хэмжээ** | **Нэр төрөл** | **Хэмжээ** |
| **1.1** | **Үндсэн хоол** | | | |
| 1.1.1 | Үхрийн махтай сендвич 100% | 280 гр | Тахианы махтай сендвич 100% | 280 гр |
| **1.2** | **Амттан** | | | |
| 1.2.1 | Хатаасан жимсний цуглуулга | 30 гр | Хатаасан жимсний цуглуулга | 30 гр |
| **1.3** | **Талх** | | | |
| 1.3.1 | Булочка | 1 ш | Хулууны үртэй талх | 1 ш |
| 1.3.2 | Масло | 1 ш | Масло | 1 ш |

***Энгийн ангиллын менюны орц найрлагатай ижил.**

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **Нисэх бүрэлдэхүүний хоолны техникийн тодорхойлолт** | | | | | | | |
| **2** | **Халуун хоол /cycle 1/** | | **Халуун хоол /cycle 2/** | | **Халуун хоол /cycle 3/** | | **Халуун хоол /cycle 4/** | |
| | **Нэр төрөл** | **Хэмжээ /-аас багагүй/** | **Нэр төрөл** | **Хэмжээ /-аас багагүй/** | **Нэр төрөл** | **Хэмжээ /-аас багагүй/** | **Нэр төрөл** | **Хэмжээ /-аас багагүй/** |
| **2.1** | **Үндсэн хоол** | | | | | | | |
| 2.1.1 | Цуйван **40%** *Махны орц 110 гр-аас багагүй* | 280 гр | Үхрийн махан хуурга 40% *Махны орц 120 гр-аас багагүй* | 250 гр | Нарийн махан хуурга *Махны орц 130 гр-аас багагүй* | 250 гр | Үхрийн махан шницель 40% *Мах 150 гр* | 260 гр |
| 2.1.2 | Карритай тахиа 30% | 260 гр | Терияки тахиа 30% | 220 гр | Бяслагтай шарсан тахиа | 240 гр | Өндөгтэй хуурга 30% *Махны орц 120 гр-аас багагүй* | 250 гр |
| 2.1.3 | Төмсний хучмал 30% *Мах 150 гр-аас багагүй* | 260 гр | Шпагетти болоньезе 30% | 250 гр | Хуушуур /4 ширхэг/ *Хамгийн багадаа 3 төрлийн ногооны хачиртай байна.* | 280 гр | Цуйван 30% *Мах 110 гр-аас багагүй.* | 280 гр |
| **2.2** | **Салат** | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.1 | Өргөст хэмх, улаан лоолийн салат | 80 гр | Шинэ ногооны салат | 80 гр | Өргөст хэмх, улаан лоолийн салат | 80 гр | Шинэ ногооны салат | 80 гр |
| **2.3** | **Амттан** | | | | | | | |
| 2.3.1 | Жимсний цуглуулга *//энгийн ангиллын жимсний сонголттой адилхан байна./* | 60 гр | Бяслагтай бялуу *//энгийн ангилалтай адилхан байна./* | 70 гр | Жимсний цуглуулга *//энгийн ангиллын жимсний сонголттой адилхан байна./* | 60 гр | Бяслагтай бялуу *//энгийн ангилалтай адилхан байна./* | 70 гр |
| **2.4** | **Талх** | | | | | | | |
| 2.4.1 | Булочка | 1 ш | Хулууны үртэй талх | 1 ш | Булочка | 1 ш | Хулууны үртэй талх | 1 ш |
| 2.4.2 | Масло | 1 ш 8гр | Масло | 1 ш 8 гр | Масло | 1 ш 8 гр | Хулууны үртэй талх | 1 ш |

***Үндсэн хоол тус бүрийн махны орц 110 гр-аас багагүй байхыг анхаарна уу.**

**Тусгай хоолны техникийн тодорхойлолт**

***Доорх хүснэгтийн дагуу тусгай хоолны нэршил тус бүрээр ирүүлнэ.**

| Поднос өрөлтийн задаргаа | Халуун хоол /бизнес болон энгийн ангилал/ | Хүйтэн зууш |
|---|---|---|
| **Зууш/салат** | Тусгай хоолны агуулгад нийцсэн орц, найрлага бүхий салат<br>Нийт жин: 70 гр-аас багагүй | |
| **Үндсэн хоол** | Тусгай хоолны агуулгад нийцсэн орц найрлага бүхий халуун хоол<br>Нийт жин: 250 гр-аас багагүй | Тусгай хоолны агуулгад нийцсэн халаах зориулалтгүй хүйтэн зууш, сендвич, өөр ижил төрлийн бүтээгдэхүүн байж болно.<br>Нийт жин: 200 гр-аас багагүй байна. |
| **Амттан** | Тусгай хоолны агуулгад нийцсэн орц найрлагатай жимсний цуглуулга, бялуу, панна котта, царцаамаг, хатаасан жимс ... зэрэг байж болно.<br>Нийт жин: 65 гр-аас багагүй | Тусгай хоолны агуулгад нийцсэн орц найрлагатай жимсний цуглуулга, бялуу, панна котта, царцаамаг, хатаасан жимс ... зэрэг байж болно.<br>Нийт жин: 65 гр-аас багагүй |
| **Талх**<br>**Жимсний чанамал**<br>**Масло** | Тусгай хоолны агуулгад нийцсэн талх болон хольц байх ба түүнийг орлуулах бүтээгдэхүүн санал болгоно. | |

## 1. Хүүхдийн хоол

| № | Код | Хоолны нэр | Орц найрлага |
|---|---|---|---|
| 1. | BBML | Baby meal | Baby water, juice, puree зэрэг 2 хүртэлх насны хүүхдэд зориулсан бэлэн бүтээгдэхүүн байх ба хүйтэн зууш болон халуун хоол гэсэн 2 сонголттой байна. |
| 2. | CHML | Child meal | 2-12 насны хүүхдэд зориулсан хоол хүйтэн зууш, халуун хоол |

| | | | |
|---|---|---|---|
| | | | |

## 2. Цагаан хоол

| № | Код | Хоолны нэр | Орц, найрлага |
|---|---|---|---|
| 1. | VLML | Vegetarian Lacto-Ovo Meal | Загас, шувууны мах зэрэг бүх төрлийн мах, амьтны гаралтай өөх тос болон желатин хэрэглэдэггүй, -Өндөг, сүүн бүтээгдэхүүн агуулдаг барууны цагаан хоол, -Ургамлын тос ашиглах ба үр тариа, жимс жимсгэнэ, хүнсний ногоо зэргээс бүрдсэн байна. |
| 2. | VGML | Vegetarian Vegan Meal | Загас, шувууны мах зэрэг бүх төрлийн мах, амьтны гаралтай өөх тос болон желатин, өндөг, сүүн бүтээгдэхүүний найрлагыг хориглодог цагаан хоол, -Ургамлын тос ашиглах ба үр тариа, жимс жимсгэнэ, хүнсний ногоо зэргээс бүрддэг ба хүйтэн зууш болон халуун хоол гэсэн 2 сонголттой байна. |
| 3. | AVML | Vegetarian Hindu Meal | Загас, шувууны мах зэрэг бүх төрлийн мах, өндөг зэргийн хориглодог.<br>Сүү, сүүн бүтээгдэхүүнийг зөвшөөрдөг цагаан хоол ба хүйтэн зууш болон халуун хоол гэсэн 2 сонголттой байна. |
| 4. | VJML | Vegetarian Jain Meal | Загас, шувууны мах зэрэг бүх мах, өндөг, сүүн бүтээгдэхүүн, сонгино, сармис, цагаан гаа гэх мэт үндэслэг хүнсний ногоог хатуу хориглодог Энэтхэг цагаан хоол ба хүйтэн зууш болон халуун хоол гэсэн 2 сонголттой байна. |
| 5. | VOML | Vegetarian Oriental Meal | Загас, шувууны мах зэрэг бүх мах, өндөг, сүүн бүтээгдэхүүнийг хориглоно. -Сонгино, сармис, цагаан гаа гэх мэт үндэслэг хүнсний ногоог зөвшөөрдөг цагаан хоол ба хүйтэн зууш болон халуун хоол гэсэн 2 сонголттой байна. |
| 6. | RVML | Raw Vegetarian Meal | Кофейн агуулсан ундаа, хадгалах болон нэмэлт бодис агуулсан бүтээгдэхүүн, боловсруулсан бэлэн бүтээгдэхүүнийг хориглоно. - Цэвэр түүхий ногоо, түүхий жимс, түүхий жимс болон хүнсний ногооны шүүс, сүүн бүтээгдэхүүн, талх зэрэг байх ба хүйтэн зууш болон халуун хоол гэсэн 2 сонголттой байна. |

## 3. Шашны зан үйлтэй холбоотой тусгай хоол

| № | Код | Хоолны нэр | Орц найрлага |
|---|---|---|---|
| 1. | HNML | Hindu Meal | - Цагаан хоолтон бус Энэтхэг хоол<br>- Үхрийн мах, тугалын мах, гахайн мах, түүхий загас, утсан загас ашиглахгүй, харин хонины мах, шувууны мах, далайн хоол, чанаж болгосон загасыг зөвшөөрнө. |
| 2. | KSML | Kosher Meal | - Иудей шашны уламжлалт зан үйлийн дагуу адислагдсан лацтай бэлэн бүтээгдэхүүн<br>- Агаарын хөлгийн үйлчлэгч б итүүмжийг тухайн зорчигчид үзүүлж баталгаажуулсны дараа задалж үйлчилнэ. |

| | | | |
|---|---|---|---|
| 3. | MOML | Moslem Meal | - Архи, гахайн мах, хиам, бэкон, желатин эсвэл гахайн дайвар бүтээгдэхүүний орц найрлагыг хориглоно.<br>- Үхэр, хонь, шувууны махыг “Исламын хууль”-д нийцүүлэн бэлдсэн байх ёстой. |

## 4. Эрүүл мэндтэй холбоотой тусгай хоол

| № | Код | Хоолны нэр | Орц, найрлага |
|---|---|---|---|
| 1. | BLML | Bland Meal | - Хоол боловсруулах эрхтний үйл ажиллагаа доголдсон зорчигчдод зориулсан хоол<br>- Хурц, халуун ногоо, гэдэсний хий үүсгэдэг хүнсний ногоо, болон өөх тостой хүнсийг хязгаарлана.<br>- Өөх тос багатай мах, цагаан загас ашиглан бэлдэнэ. |
| **2.** | DBML | Diabetic Meal | - Калори, уураг, өөх тос, элсэн чихрийн хэрэглээг хязгаарлахаас гадна хоолны цаг, хэмжээг харгалзан үзнэ.<br>- Мөн ханасан тосны хүчлийн хэрэглээг хязгаарлан хоолны дэглэмийг тохируулна.<br>- Өөх тос багатай сүүн бүтээгдэхүүн, бүхэл үрийн гурилаар барьсан талх, сереал зэрэг байна. |
| **3.** | GFML | Gluten Intolerant Meal | - Хоолны найрлага дахь цавуулаг агууламжийг хатуу хязгаарласан хоол<br>- Улаан буудай, арвай, хөх тариа, овъёос, соёолж зэрэг цавуулаг агуулсан орц найрлагыг оруулалгүй будаа, төмс, амтат төмс, эрдэнэ шиш, шар буурцаг зэргээр орлуулдаг. |
| **4.** | LCML | Low Calorie Meal | - Биеийн жингээ хянах зорилгоор хүнсний илчлэгийг хязгаарласан хоол,<br>- Хуурч хайрч болгоогүй байх бөгөөд өөх тос ихтэй сүмс, өтгөн амттан оруулдаггүй.<br>- Өөх тос багатай мах, сүүн бүтээгдэхүүн байна.<br>- Хоол хийхэд шаардагдах хамгийн бага хэмжээгээр өөх тос, элсэн чихрийг хэрэглэдэг. |
| **5.** | LFML | Low Fat Meal | - Холестерол ихтэй өөх тос ихтэй мах, өтгөрүүлсэн шөл, өндөгний шар, хясаа гэх мэтийг ашиглахгүй бөгөөд тослог багатай мах, загас гэх мэтийг ашиглана.<br>- Хайруулын тавганд хуурч хайрахын оронд уураар жигнэх аргыг ашиглана.<br>- Чухал ханасан тосны хүчлийн зөвшөөрөгдөх хэмжээнд чидун жимсний тос, эрдэнэ шишийн тос зэрэг ургамлын тосыг хэрэглэдэг. |
| **6.** | LSML | Low Salt Meal | - Утсан, давсалсан бүтээгдэхүүнийг хязгаарлах ба натрийн агууламж бага цөцгийн тос, маргарин ашигладаг.<br>- Кетчуп, гич зэрэг бэлэн бүтээгдэхүүний давсны хэмжээг харгалзан зөвшөөрөгдөх хэмжээнд хэрэглэнэ. |
| **7.** | NLML | Low Lactose Meal | - Лактоз агуулсан бүх төрлийн сүүн бүтээгдэхүүн (сүү, цөцгий, хүүхдийн сүү гэх мэт)-ий хатуу хязгаарлалттай хоол |

| | | | |
|---|---|---|---|
| | | | - Лактаз ферментийн дутагдлаас болж хоол боловсруулах үйл ажиллагаа нь доголдолтой зорчигчид зориулсан хоол<br>- Сүү, тараг, бяслаг, зайрмаг, хуурай сүү, шербет, пудинг, сүүн бүтээгдэхүүн агуулсан талх/сереал/омлет/блинчик(crepe) зэрэг өндөгтэй хоол, шоколад, карамелийн төрлийн бүтээгдэхүүн хэрэглэдэггүй.<br>- Сүү, сүүн бүтээгдэхүүн агуулаагүй махан төрлийн бүтээгдэхүүн, шувууны мах, хүнсний ногоо, шар буурцагны сүү хэрэглэнэ. |

## 5. Бусад

| № | Код | Хоолны нэр | Орц, найрлага |
|---|---|---|---|
| 1. | FPML | Fruit Platter Meal | - Нислэгийн ердийн хоолны оронд хөнгөн хоол идэхийг хүссэн үйлчлүүлэгчдэд зориулсан, зөвхөн шинэхэн жимснээс бүрдсэн хоол |
| 2. | SFML | Seafood Meal | - Загас, далайн хоол нь үндсэн орц бөгөөд үр тариа, хүнсний ногоо, жимстэй хамт үйлчилнэ. |
| 3. | CLML | Celebration Meal | - Төрсөн өдрөөрөө зорчиж буй зорчигчдод зориулсан бялуу -Энгийн хоолны хамт үйлчилнэ. |

## 6. Тоног төхөөрөмж

Тендерт шалгарсан оролцогч доорх 2 тоног төхөөрөмжийг өөрийн зардлаар бэлдэнэ.

6.1 Гадны биет илрүүлэх төхөөрөмж

6.2 Монгол Улсын Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам /ИНАБЖ/-ын Бүлэг 9, Бүлэг 10, ИНД-108.53.b.5, 108.55.b.10-т тус тус заасны дагуу нислэгийн хоол хүнсээр дамжуулан хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болох эд зүйлс нэвтрүүлэхээс сэргийлэх аюулгүй байдлын үзлэгийн тоног төхөөрөмж /Aviation security x-ray/

**ҮНИЙН САНАЛ АВАХ ХҮСНЭГТ:**

*Нэгж хоолны үнийг CYCLE тус бүрээр тооцохдоо 2-3 сонголт бүхий үндсэн хоолны үнийг дундажлан бодно.

1. БИЗНЕС АНГИЛЛЫН ХООЛНЫ ҮНЭ

| **Нислэгийн чиглэл** | | **Хоолны үйлчилгээний төрөл** | **Cycle 1** | | **Cycle 2** | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | **Нэгж үнэ /төгрөгөөр/** | **Тоо ширхэг** | **Нэгж үнэ /төгрөгөөр/** | **Тоо ширхэг** |
| 1 | Улаанбаатар-Сөүл | Халуун өглөөний цай | | 3156 | | 3157 |
| 2 | Улаанбаатар-Бангкок | *1-р үйлчилгээ:*<br>Халуун өглөөний цай<br>*2-р үйлчилгээ:*<br>Халуун өдрийн хоол | | 332 | | 331 |
| 3 | Улаанбаатар-Пукет | 1-р үйлчилгээ:<br>Өглөөний цай<br>2-р үйлчилгээ:<br>Өдрийн хоол | | 134 | | 133 |
| 4 | Улаанбаатар-Хонг Конг | Халуун өглөөний цай | | 940 | | 940 |
| 5 | Улаанбаатар-Москва | 1-р үйлчилгээ:<br>Халуун өглөөний цай<br>2-р үйлчилгээ:<br>Халуун өдрийн хоол | | 306 | | 306 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6 | Улаанбаатар-Бээжин | UBN-PEK:<br>Өглөөний цай /халуун/ | | 1539 | | 1539 |
| 7 | Бээжин-Улаанбаатар | PEK-UBN:<br>Халуун өдрийн хоол | | 1882 | | 1881 |
| 8 | Улаанбаатар-Бусан | Халуун өглөөний цай | | 336 | | 336 |
| 9 | Улаанбаатар-Гуанжоу | Халуун өдрийн хоол | | 204 | | 204 |
| 10 | Улаанбаатар-Осака | Халуун өдрийн хоол | | 107 | | 107 |
| 11 | Улаанбаатар-Сингапур | Халуун өдрийн хоол | | 200 | | 199 |
| 12 | Улаанбаатар-Хо Ши Минь | Халуун өдрийн хоол | | 119 | | 119 |
| 13 | Улаанбаатар-Эрээн | | | - | | - |
| 14 | Улаанбаатар-Сан Франциско | 1-р үйлчилгээ:<br>Халуун өглөөний цай<br>2-р үйлчилгээ:<br>Халуун өдрийн хоол | | 516 | | 515 |
| 15 | Захиалгат нислэг | Халуун өдрийн хоол | | - | | - |
| 16 | | Хүйтэн зууш | | - | | - |
| Тус бүрийн нийт үнэ: | | | | | | |
| **НИЙТ ҮНЭ:** | | | | | | |

***Тайлбар: Захиалгат нислэгийн хоолны үнэ нислэгийн зайнаас хамааран үндсэн хоолны үйлчилгээ болон давтамжтай ижил байна.**

## 2. ЭНГИЙН АНГИЛЛЫН ХООЛНЫ ҮНЭ

| **Нислэгийн чиглэл** | | **Хоолны үйлчилгээний төрөл** | **Cycle 1** | | **Cycle 2** | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | **Нэгж үнэ /төгрөгөөр/** | **Тоо ширхэг** | **Нэгж үнэ /төгрөгөөр/** | **Тоо ширхэг** |
| 1 | Улаанбаатар-Сөүл | Халуун өдрийн хоол | | 61202 | | 61201 |
| 2 | Улаанбаатар-Бангкок | Халуун өдрийн хоол | | 7038 | | 7038 |
| 3 | Улаанбаатар-Пукет | Халуун өдрийн хоол | | 2938 | | 2937 |
| 4 | Улаанбаатар-Хонг Конг | Халуун өдрийн хоол | | 18225 | | 18224 |
| 5 | Улаанбаатар-Москва | 1-р үйлчилгээ: Халуун өдрийн хоол<br>2-р үйлчилгээ: Хүйтэн зууш/сендвич | | 6094 | | 6094 |
| 6 | Улаанбаатар-Бээжин | UBN-PEK:  Хүйтэн зууш/сендвич | | 32496 | | 32496 |
| 7 | Бээжин-Улаанбаатар | PEK-UBN: Хүйтэн зууш/сендвич | | 32495 | | 32494 |
| 8 | Улаанбаатар-Бусан | Халуун өдрийн хоол | | 6137 | | 6137 |
| 9 | Улаанбаатар-Гуанжоу | Халуун өдрийн хоол | | 3726 | | 3725 |
| 10 | Улаанбаатар-Осака | Халуун өдрийн хоол | | 2077 | | 2076 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 11 | Улаанбаатар-Сингапур | Халуун өдрийн хоол | | 3124 | | 3123 |
| 12 | Улаанбаатар-Хо Ши Минь | Халуун өдрийн хоол | | 2261 | | 2261 |
| 13 | Улаанбаатар-Эрээн | Сендвич | | 5005 | | 5005 |
| 14 | Эрээн-Улаанбаатар | Сендвич | | 5005 | | 5005 |
| 15 | Улаанбаатар-Сан Франциско | 1-р үйлчилгээ: Халуун өдрийн хоол<br>2-р үйлчилгээ: Халуун өдрийн хоол | | 7415 | | 7415 |
| 16 | Захиалгат нислэг | Халуун өдрийн хоол | | | | |
| 17 | | Хүйтэн зууш | | | | |
| Тус бүрийн нийт үнэ: | | | | | | |
| **НИЙТ ҮНЭ:** | | | | | | |

***Тайлбар: Захиалгат нислэгийн хоолны үнэ нислэгийн зайнаас хамааран үндсэн хоолны үйлчилгээ болон давтамжтай ижил байна.**

3. НИСЭХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХООЛНЫ ҮНЭ /Нисгэгч/

| **Нислэгийн чиглэл** | **Хоолны үйлчилгээний төрөл** | **Cycle 1** | | **Cycle 2** | |
|---|---|---|---|---|---|
| | | **Нэгж үнэ /төгрөгөөр/** | **Тоо ширхэг** | **Нэгж үнэ /төгрөгөөр/** | **Тоо ширхэг** |
| Улаанбаатар- Сөүл, Токио, Хонгконг, Бусан, Гуанжоу, Осака, Сингапур | Халуун өдрийн хоол | | 1568 | | 1568 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Улаанбаатар-Бангкок, Пукет, Франкфурт, Истанбул, Москва, Сан-Франциско, Хо Ши Мин | *1-р үйлчилгээ:*<br>Халуун өдрийн хоол<br>*2-р үйлчилгээ:*<br>Халуун өдрийн хоол | | 845 | | 845 |
| Улаанбаатар-Бээжин<br>Бээжин-Улаанбаатар | Өглөөний цай /халуун/ | | 526 | | 526 |
| Тус бүрийн нийт үнэ: | | | | | |
| **НИЙТ ҮНЭ: /төгрөгөөр/** | | | | | |

4. НИСЭХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХООЛНЫ ҮНЭ /Бүхээгийн ажилтан/

| **Нислэгийн чиглэл** | **Хоолны үйлчилгээний төрөл** | **Cycle 1** | | **Cycle 2** | |
|---|---|---|---|---|---|
| | | **Нэгж үнэ /төгрөгөөр/** | **Тоо ширхэг** | **Нэгж үнэ /төгрөгөөр/** | **Тоо ширхэг** |
| Улаанбаатар- Сөүл, Токио, Хонгконг, Бусан, Гуанжоу, Осака, Сингапур | Халуун өдрийн хоол | | 4800 | | 4800 |
| Улаанбаатар-Бангкок, Пукет, Франкфурт, Истанбул, Москва, Сан-Франциско, Хо Ши Мин | *1-р үйлчилгээ:*<br>Халуун өдрийн хоол<br>*2-р үйлчилгээ:*<br>Халуун өдрийн хоол | | 3256 | | 3256 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Улаанбаатар-Бээжин<br>Бээжин-Улаанбаатар | Өглөөний цай /халуун/ | | 2630 | | 2630 |
| Тус бүрийн нийт үнэ: | | | | | |
| **НИЙТ ҮНЭ: /төгрөгөөр/** | | | | | |

4. ТУСГАЙ ХООЛНЫ ҮНЭ

| д/д | SSR code | Тусгай хоолны нэр /Special meal/ | Үнэ /төгрөгөөр/ | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Халуун хоол | | Хүйтэн зууш |
| | | | Бизнес ангилал | Энгийн ангилал | |
| 1 | AVML | VEGETARIAN HINDU MEAL REQUEST | | | |
| 2 | BBML | BABY MEAL REQUEST | | | |
| 3 | BLML | BLAND MEAL REQUEST | | | |
| 4 | CHML | CHILD MEAL REQUEST | | | |
| 5 | DBML | DIABETIC MEAL REQUEST | | | |
| 6 | FPML | FRUIT PLATTER MEAL REQUEST | | | |
| 7 | GFML | GLUTEN INTOLERANT MEAL REQUEST | | | |
| 8 | HNML | HINDU MEAL REQUEST | | | |
| 9 | KSML | KOSHER MEAL REQUEST | | | |
| 10 | LCML | LOW CALORIE MEAL REQUEST | | | |
| 11 | LFML | LOW FAT MEAL REQUEST | | | |
| 12 | LSML | LOW SALT MEAL REQUEST | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 13 | MOML | HALAAL MEAL REQUEST | | | |
| 14 | NLML | LOW LACTOSE MEAL REQUEST | | | |
| 15 | RVML | VEGETARIAN ROW MEAL | | | |
| 16 | SFML | SEAFOOD MEAL | | | |
| 17 | VGML | VEGETARIAN VEGAN MEAL | | | |
| 18 | VJML | VEGETARIAN JIAN MEAL | | | |
| 19 | VLML | MEAL ON BOARD NOT REQUIR | | | |
| 20 | VOML | CELEBRATION MEAL | | | |
| 21 | PFML | PEANUT FREE MEAL | | | |
| 22 | CLML | CELEBRATION MEAL | | | |

***Тайлбар:** Тусгай хоол нь нислэгийн чиглэлээс хамаарч үндсэн үйлчилгээний давтамжтай адил байна.

***Поднос өрөлтийн задаргааг 2 cycle-ийн дундаж дүнг тооцоолон ирүүлнэ.**

**Нэмэлт бүтээгдэхүүн:**

| № | Нэр төрөл | Хэмжээ | Үнийн санал |
|---|---|---|---|
| 1 | Лимон | Нислэг бүрт 3 ширхэгийг зүсэж 2 саванд хийж бэлтгэнэ. | |
| 2 | Хуурай мөс | Шаардлагатай тохиолдолд нэмэлтээр захиална. | |

**БҮТЭЭГДЭХҮҮН /Поднос өрөлт/-ИЙ ҮНИЙН ЗАДАРГАА**

| | Бизнес ангилал | | |
|---|---|---|---|
| | **Бүтээгдэхүүний нэр, төрөл** | **Нэгж үнэ** | **Нэгж үнэ (2 үйлчилгээтэй нислэг)** |
| 1. | Зууш | | |
| 2. | Үндсэн хоол | | |

| | | | |
|---|---|---|---|
| 3. | Дессерт | | |
| 4. | Талх | | |
| 5. | Масло | | |
| 6. | Жимсний чанамал | | |
| 7. | Зөгийн бал | | |
| **НИЙТ** | | | |

| | **Энгийн ангиллын халуун хоол** | | | **Энгийн ангиллын хүйтэн зууш / сендвич** |
|---|---|---|---|---|
| | **Бүтээгдэхүүний нэр, төрөл** | **Нэгж үнэ** | **Нэгж үнэ (2 үйлчилгээтэй нислэг)** | |
| 1 | Салад | | | |
| 2 | Үндсэн хоол | | | |
| 3 | Дессерт | | | |
| 4 | Талх | | | |
| 5 | Масло | | | |
| 6 | Жимсний чанамал | | | |
| 7 | Зөгийн бал | | | |
| **НИЙТ** | | | | |

| | **Нисэх бүрэлдэхүүн** | | |
|---|---|---|---|
| | **Бүтээгдэхүүний нэр, төрөл** | **Нэгж үнэ** | **Нэгж үнэ /2 үйлчилгээтэй нислэг/** |
| 1 | Салад | | |
| 2 | Үндсэн хоол- Халуун хоол | | |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | Үндсэн хоол- Хүйтэн зууш | | |
| 4 | Дессерт | | |
| 5 | Талх | | |
| 6 | Масло | | |
| 7 | Жимсний чанамал | | |
| 8 | Зөгийн бал | | |
| НИЙТ | | | |

**БИЗНЕС ЛОУНЖИЙН ХООЛ**

| д/д | Барааний нэр | Гэрээний хугацаанд авах нийт тоо ширхэг | Хэмжээ: | Техникийн тодорхойлолт |
|---|---|---|---|---|
| 1 | Тахианы махан ороомог | 6,000 | 220-280 грамм нэг удаагийн хоолны зориулалттай савлагаатай. | Орц: Чинцай, лууван бяслагтай, тахианы гуяны цул мах, будаа, брокли хулуу шар чинжүүтэй.<br>Халааж хэрэглэхэд амт чанараа алдахгүй байх.<br>24 цаг хадгалах боломжтой байх. |
| 2 | Энэтхэг тахианы махан хуурга | 6,000 | 220-280 грамм нэг удаагийн хоолны зориулалттай савлагаатай. | Тахианы гуяны мах, лууван, төмс, цагаан будаа, хайрсан ногоо<br>Халааж хэрэглэхэд амт чанараа алдахгүй байх.<br>24 цаг хадгалах боломжтой байх. |
| 3 | Үхрийн жигнэсэн мах | 6,000 | 220-280 грамм нэг удаагийн хоолны зориулалттай савлагаатай. | Улаан дарсанд жигнэсэн үхрийн гуяны мах, хайрсан төмс лууван, цагаан будаа<br>Халааж хэрэглэхэд амт чанараа алдахгүй байх.<br>24 цаг хадгалах боломжтой байх. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | Амталсан гахайн хавирга | 6,000 | 220-280 грамм нэг удаагийн хоолны зориулалттай савлагаатай. | Гахайн хавирга, BBQ соус, цагаан будаа хайрсан төмс, лууван Нэг удаагийн савлагаатай 220-280гр хооронд /хоол/<br>Халааж хэрэглэхэд амт чанараа алдахгүй байх.<br>24 цаг хадгалах боломжтой байх. |
| 5 | Терияки гахай | 3,650 | 220-280 грамм нэг удаагийн хоолны зориулалттай савлагаатай. | Терияки соусанд дарсан гахайн гуяны мах, цагаан будаа, хуурсан ногоо<br>Халааж хэрэглэхэд амт чанараа алдахгүй байх.<br>24 цаг хадгалах боломжтой байх. |
| 6 | Үхрийн махтай удон гоймонтой хуурга | 3,650 | 220-280 грамм нэг удаагийн хоолны зориулалттай савлагаатай. | Үхрийн гуяны мах, удон гоймон, гүндийн тос, соё соус, лууван, амтат чинжүү, мөөг /хоол/<br>Халааж хэрэглэхэд амт чанараа алдахгүй байх.<br>24 цаг хадгалах боломжтой байх. |
| 7 | Цагаан хоол | 1,825 | 220-280 грамм нэг удаагийн хоолны зориулалттай савлагаатай. | Нэг удаагийн савлагаатай Ногооны котлет. /нэг удаагийн байгалд ээлтэй сав баглаатай байх/<br>Халааж хэрэглэхэд амт чанараа алдахгүй байх.<br>24 цаг хадгалах боломжтой байх. |
| 8 | Хуурай шарсан хонины хавирга | 2,000 | 220-280 грамм нэг удаагийн хоолны зориулалттай савлагаатай. | Гоньд цагаан гаа, саримсаар амталж шарсан хонины хавирга, цагаан будаа, хайрсан ногоо.<br>Халааж хэрэглэхэд амт чанараа алдахгүй байх.<br>24 цаг хадгалах боломжтой байх. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 9 | Үхрийн махан карри | 2,000 | 220-280 грамм нэг удаагийн хоолны зориулалттай савлагаатай. | Үхрийн гуяны мах, алтан япон карри, цагаан будаа.<br>Халааж хэрэглэхэд амт чанараа алдахгүй байх.<br>24 цаг хадгалах боломжтой байх. |
| 10 | Цезарь салат | 6,000 | Нэг удаагийн савлагаатай /150-200гр/ /соус сонголттой/ | Үндсэн материал: Тахианы ясгүй мах, Үрлэн улаан лооль, Оливын тос, Пармезан, Талх, Сармис, Айсберг салатны навч<br>24 цаг хадгалах боломжтой байх.<br>Нэг удаагийн савлагаатай Цезарь салат /соус сонголттой/ |
| 11 | Шинэ ногооны салат | 6,000 | Нэг удаагийн савлагаатай /150-200гр/ /соус сонголттой/ | Нэг удаагийн савлагаатай Шинэ ногооны салат / Салатны байцаа, Улаан лооль, Өргөст хэмх, Сонгино тал, Лаазалсан эрдэнэ шиш, майонез, Тараг, Сармис, Элсэн чихэр, Давс болон хар перц, Лемоны шүүс, Яншуй гэх мэт<br>24 цаг хадгалах боломжтой байх. |

## IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 32.1-д үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ашиглахаар заасан бол захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна энэ хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзахгүй.

1. *Үйлчилгээ дуусгах хугацаа:* ***[“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих]***

   *Хэрэв “ашиглах” бол: Тухайн тендер шалгаруулалтад холбогдох гэрээний дагуу гүйцэтгэх хуваарьт заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (гэрээний үүргийн гүйцэтгэлийг эхлэх эхний өдрөөс хойш үүрэг гүйцэтгэвэл зохих сүүлчийн өдрийг оролцуулан) гэрээний үүргийг хэрэгжүүлсэн байх шаардлагатай. Захиалагчийн заасан гэрээний үүрэг гүйцэтгэх хугацаанаас өмнө гүйцэтгэх санал ирүүлсэн тендерт урамшуулал, эсхүл үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл олгохгүй.*

   *Захиалагч уг шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд ашиглахаар тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарьт зааснаас хоцорч гүйцэтгэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд* ***[хувь бичих]****–аар тооцож тендерийн харьцуулах үнэ дээр нэмнэ.*

   *Захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарьт зааснаас* ***[тоо бичих]****-аас илүү* ***[“сар”, “өдөр” гэдэг үгнээс сонгож бичих]*** *хоцроож гүйцэтгэх санал болгосон тендерээс татгалзана. Харин өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрөөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон гүйцэтгэлийн хуваариас хойш гүйцэтгэх санал ирүүлсэн тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.*

2. *Үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж:* ***[“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих.]***

   *Хэрэв “ашиглах” бол урсгал засвар үйлчилгээний цэг бий болгох болон үндсэн/шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангахын тулд захиалагчид шаардагдах зардлыг тусад нь үнэлж ирүүлсэн бол түүнийг үнэлгээний зорилгоор тендерийн харьцуулах үнэ дээр нэмж үнэлнэ.*

3. *Байгаль орчинд нөлөөлөх байдал:* ***[“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих.]***

   *Гэрээний гүйцэтгэлийн явцад байгаль орчинд нөлөөлөх байдалтай холбоотой дараах үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж үнэлнэ.* ***[Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]***

4. *Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт:* ***[“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих.]***

   *Гэрээний гүйцэтгэлд хамаарах хуульд нийцсэн дараах үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж үнэлнэ.* ***[Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]***

*Тухайлбал хуулийн 12.3-т заасныг үндэслэн тендерийн үнэлгээнд эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх тендерийн харьцуулах үнийг тодорхойлж болно.*

## V БҮЛЭГ.ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ Маягт 1.Тендер илгээх маягт

***[огноо]***

***[Захиалагч байгууллагын нэр]***-д

Манай ***[оролцогчийн нэр]*** нь танай байгууллагаас зарласан ***[тендер шалгаруулалтын нэр, дугаар]*** тендер шалгаруулалтад ***[үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр]*** төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу үйлчилгээ үзүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид "**тендер**" гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:

   2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;

   2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;

   2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.

   2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт ***["санал болгоно" эсхүл "санал болгохгүй" гэж бичих]***. ***[Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих]***.
5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш ***[ажлын 30 ба түүнээс дээш хоногийн тоо]*** хоногийн хугацаанд хүчинтэй байна.[1]
6. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч

[1] Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол "*5. Тендер нь тендерийн баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.*" гэж сольж бичнэ үү.

баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.

7. Тендерт санал болгосон үйлчилгээ нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.

8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

***[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,***

***эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,***

***албан тушаал, гарын үсэг,***

***байгууллагын тамга, тэмдэг]:***

***Хаяг:***

**Маягт 2. Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээний мэдээлэл**

| Гэрээний нэр | Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас | Төсөвт өртөг | Хугацаа /эхэлсэн, дууссан/ |
|---|---|---|---|
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

**Маягт 3.Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл**

Оролцогчийн нэр: *[түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].*

| | |
|---|---|
| 1. | Захиалагчийн нэр |
| 2. | Гэрээний нэр |
| 3. | Гэрээний дугаар |
| 4. | Гэрээ байгуулсан огноо |
| 5. | Гэрээ дуусгавар болсон огноо |
| 6. | Гэрээний дүн |
| 7. | Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил |
| | Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох)<br>□Үндсэн нийлүүлэгч □Түншлэлийн гишүүн □Туслан гүйцэтгэгч |

**Маягт 4.Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл**

| Гэрээний нэр | Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас | Төсөвт өртөг | Гэрээ эхэлсэн хугацаа | Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

**Маягт 5. Үйлчилгээг үзүүлэх ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга**

Техникийн тодорхойлолтод тусгагдсан ажлын даалгаврыг гүйцэтгэх аргачлалын талаарх танилцуулга болон хэрэв ажлын даалгаврын талаар гаргах санал, зөвлөмж ирүүлнэ.

**Маягт 6. Үйлчилгээ үзүүлэх хуваарь**

Техникийн тодорхойлолтод тусгагдсан ажлын даалгаврын дагуу үзүүлэх үйлчилгээг гүйцэтгэх хуваарийг боловсруулж ирүүлнэ.

**Маягт 7.Хүний нөөцийн мэдээлэл**

| Албан тушаал | Ажилтны нэр | Боловсрол, мэргэжлийн ур чадвар | Нийт ажлын туршлага, жилээр | Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр |
|---|---|---|---|---|
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

**Маягт 10. Санал болгож буй ажилтны жишиг намтар (cv)**

Санал болгож буй албан тушаал: ______________________________________________

Овог, нэр: ____________________________________________________________________

Мэргэжил:_____________________________________________________________________

Төрсөн он, сар, өдөр: _________________________________________________________

Тухайн байгууллагад ажилласан жил:_______________________Иргэншил:__________

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл:_________________________________________________

Хариуцах ажил: ________________________________________________________________

Ур чадварын:

*[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн зөвлөх үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршлыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]*

_____________________________________________________________________________

Боловсрол:

*[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]*

Ажилласан туршлага:

*[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]*

_____________________________________________________________________________

Хэлний мэдлэг:

[*Эзэмшсэн хэлний мэдлэгийн түвшинг ярих, унших, бичих тус бүрт онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.*]

_____________________________________________________________________________

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: _________________________________ Огноо:_______

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: ______________________ Огноо:_______

## Маягт 11. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

| **Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт** | **Хүчин чадал** | **Тоо ширхэг** | ***[“Өөрийн эзэмшил” эсхүл “түрээс” аль нэгийг бичих]*** |
|---|---|---|---|
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

## Маягт 12.Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

| | | **Нууцалсан баримт бичиг, мэдээлэл** | **Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл** |
|---|---|---|---|
| 1. | | | |
| 2. | | | |
| 3. | | | |
| 4. | | | |
| 5. | | | |

## VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж үйлчилгээ үзүүлэхэд энэхүү гэрээний загварыг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), гэрээ баталгаажуулах маягт, түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас ажил, түүнтэй холбогдох бараа нийлүүлэх, үйлчилгээг үзүүлэх харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн ажлыг гүйцэтгүүлэх нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. *Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:*

ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн ажлыг гүйцэтгэхэд хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;

1. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан тендерт оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
2. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцох бол түүнийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
3. Гүйцэтгэх ажил, дагалдах бараа, үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
4. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
5. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг, өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. Зарим жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
6. Гэрээний зүйл болон бусад хэсгийн гарчиг нь гэрээний нөхцөлийн утга агуулгыг тайлбарлах үндэслэл болохгүй.

# ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

## НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утгыг агуулна:

1.1.1. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.2. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;

1.1.3. “Гүйцэтгэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.4. “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;

1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;

1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;

1.1.7. “Үйлчилгээ” гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;

1.1.8. “Ажлын байр” гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;

1.1.9. “Баталгаат хугацаа” гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;

1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;

1.1.11. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал“ гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Тайлбар

1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:

1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.

1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.

1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.

1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.

1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

## ХОЁР. ЗАХИАЛАГЧ

**Захиалагчийн нийтлэг үүрэг**

2.1. Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө.

2.2. Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө.

2.3. Захиалагч нь үйлчилгээ авахтай холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна.

**Захиалагчийн төлөөлөгч**

2.4. Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно.

2.5. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.

2.6. Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

**Талбайд нэвтрэх зөвшөөрөл**

2.7. Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно.

2.8. Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна.

## ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ

**Гүйцэтгэгчийн нийтлэг үүрэг**

3.1. Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө.

3.2. Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө.

3.3. Ажил гүйцэтгэхэд шаардагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна.

3.4. Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгч хариуцна.

3.5. Гүйцэтгэгч нь нийт ажлын 20 (хорь) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.

3.6. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.

3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй.

Гүйцэтгэгчийн төлөөлөгч

3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана.

3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна.

3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

Техникийн болон ажлын талбайн өгөгдөл

3.11. Захиалагч нь үйлчилгээтэй холбоотой нөхцөл байдлын талаарх өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө.

Аюулгүй байдал

3.12. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.

3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.

3.14. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална.

3.15. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

3.16. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.

3.17. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.

3.18. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.

## ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН

Ажил эхлэх

4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.

4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.

4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын

үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.

4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.

Хугацаа сунгах

4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:

4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;

4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;

4.5.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;

4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.

4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.

4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.

4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.

Ажлын явцын тайлан

4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.

4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.

4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.

## ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Гэрээний үнэ

5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.

5.2. Гэрээний үнэд хуулийн 11.11-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.

5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.

Урьдчилгаа төлбөр

5.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.

5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно.

| | | |
|---|---|---|
| Төлбөрийн нөхцөл | 5.6. | Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнө. |
| | 5.7. | Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно. |
| | 5.8. | Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ. |
| | 5.9. | Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй. |
| | 5.10. | Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна. |
| | 5.11. | Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана. |

## ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА

| | | |
|---|---|---|
| Урьдчилгаа төлбөрийн баталгаа | 6.1. | ГЕН-ийн 5.4-д заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ. |
| Гүйцэтгэлийн баталгаа | 6.2. | Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ. |
| | 6.3. | Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:<br>6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;<br>6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;<br>6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон. |
| | 6.4. | Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй. |
| | 6.5. | ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна. |
| | 6.6. | Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө. |
| Чанарын баталгаа | 6.7. | Үйлчилгээний чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана. |
| | 6.8. | Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 42.5-д заасны дагуу баталгаажуулж болно. |

6.9. ГЕН-ийн 6.9-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.

6.10. Баталгаат хугацаанд үйлчилгээнд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.

6.11. ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно.

6.12. ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.

Баталгаат хугацаа

6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.

6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

## ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ

Бусдад учруулсан хохирлыг арилгах

7.1. Үйлчилгээ үзүүлэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.

7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.

Захиалагчийн хүлээх эрсдэл

7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:

7.3.1. Үйлчилгээний үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;

7.3.2. гүйцэтгэсэн үйлчилгээг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн болович захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;

7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас үйлчилгээ, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан;

7.3.4. Захиалагчийн ажлын даалгаврын алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл.

7.4. Үйлчилгээний доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.

Даатгал

7.5. Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.

7.6. Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.

7.7. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.

7.8. Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.

7.9. Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

## НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ

Доголдлыг илрүүлэх, арилгах

8.1. Гүйцэтгэгчээс ирүүлсэн үйлчилгээ, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна.

8.2. Захиалагчийн төлөөлөгч үйлчилгээний явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө.

8.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.

8.4. Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ.

8.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.

8.6. Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно.

8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө.

8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана.

Далд доголдол

8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.

Зураг төслийн доголдол

8.10. Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үүссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна.

8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна.

## ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

Захиалагч гэрээг цуцлах

9.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:

9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр үйлчилгээ үзүүлээгүй;

9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гараагүй;

9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;

9.1.4. Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгийн гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;

9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;

9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 20 (хорь)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;

9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.

9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.

9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно.

**Гүйцэтгэгч гэрээг цуцлах**

9.3. Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:

9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;

9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;

9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол.

**Гэрээг цуцлах журам**

9.4. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.

9.5. Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.

9.6. Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.

9.7. Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэснээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.

Гэрээг цуцалсны дараах төлбөр

9.8. ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.

9.9. ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:

- 9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;
- 9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал;
- 9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр;
- 9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;
- 9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.

## АРАВ. БУСАД ЗААЛТ

Мэдэгдэл

10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.

10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.

10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.

10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:

- 10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
- 10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.

10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.

10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т заасанаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.

**Төлөөлөгч өөрчлөгдөх**

10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.

10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.

10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.

**Үйлчилгээнд өөрчлөлт, залруулга хийх нөхцөл**

10.12. Талууд үйлчилгээний чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын ерөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.

10.13. Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.

10.14. Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-т заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.

10.15. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.

**Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал**

10.16. Үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.

10.17. Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.

10.18. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.

10.19. Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-ийн 4.5-д заасан хүсэлтийг гаргаж болно.

| | | |
|---|---|---|
| Оюуны өмчийн эрх зөрчих | 10.20. | Үйлчилгээг үзүүлэх явцад болон үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана. |
| Алданги | 10.21. | Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө. |
| | 10.22. | Гүйцэтгэгч нь үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө. |
| | 10.23. | Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй. |
| | 10.24. | Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө. |
| Маргаан шийдвэрлэх | 10.25. | Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. |
| | 10.26. | Маргааныг зөвшилцөж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ. |

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

| | |
|---|---|
| ГЕН 4.1. | Үйлчилгээ үзүүлж эхлэх хугацаа**:** ***Гэрээ байгуулагдсанаас хойш нэг жил*** |
| ГЕН 4.2. | Үйлчилгээ үзүүлэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа:<br>**Нэг цагт 150-аас 300 хүртэл хүний суудалтай, 4-өөс доошгүй агаарын хөлөгт өдөрт зорчигчийн тооноос хамаарч 500-2300 хоол үйлдвэрлэл, хүргэлт, ачилт хийх чадвартай байх.** |
| ГЕН 4.9. | Үйлчилгээний явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: ***[он, сар, өдөр]*** |
| ГЕН 5.2. | Үнийн тохируулга***: "Хийхгүй"*** |
| ГЕН 5.4. | Урьдчилгаа төлбөр олгох эсэх: ***"Үгүй"*** |
| ГЕН 5.5. | Урьдчилгаа төлбөр олгох хугацаа: |
| ГЕН 5.6. | Төлбөр төлөх хугацаа:<br>Төлбөрийг хэсэгчилсэн төлөх бол төлбөр төлөх үе шатны хугацаа: ***Гүйцэтгэлээр сард 1 удаа.*** |
| ГЕН 6.1. | Урьдчилгаа төлбөрийн хэмжээ:<br>Урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлэх хугацаа: |
| ГЕН 6.7. | **Чанарын баталгаа:**<br>Чанарын баталгаа шаардах эсэх: ***["Шаардана" эсхүл "Шаардахгүй" гэдгээс аль нэгийг сонгож бичих.]***<br>*Чанарын баталгаа шаардах бол,*<br>Чанарын баталгааны хэмжээ: **[Гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийн хооронд сонго.]** |
| ГЕН 6.13. | Баталгаат хугацаа: ***[Тендер шалгаруулалтын баримт бичигт үндэслэн баталгаат хугацааг тогтоож бичих]*** |
| ГЕН 7.5. | Даатгал:<br>- **Нисэх буудлын аюулгүй ажиллагаа: Нисэх буудлын аюулгүйн ажиллагаа, хог хаягдал болон холбогдон гарах төлбөрийг хариуцах.**<br>- **Кейтерингийн байр болон тоног төхөөрөмжийн даатгалыг тендерт шалгарсан компани нь кейтерингийн гэрээний хүчинтэй хугацаанд хариуцах.**<br>- **МИАТ ТӨХК-ийн байрыг түрээслэх тохиолдолд даатгалыг захиалагч бүрэн хариуцна.** |
| ГЕН 10.21. | **Захиалагчийн төлөх алдангийн хувь:**<br>Алдангийн хувь: ***Хугацаа хэтэрсэн хоног тутамд төлбөл зохих үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алданги төлнө.*** |
| ГЕН 10.22. | **Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь:**<br>Алдангийн хувь: ***Хугацаа хэтэрсэн хоног тутамд нийлүүлэх барааны үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алданги төлнө.*** |

## ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

***[Тендер шалгаруулалтын нэрийг бичих]*** гэрээ**.**

Дугаар № ***[Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]***

..............................
хот/аймаг

Нэг талаас ***[захиалагчийн нэрийг бичих]*** (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас ***[гүйцэтгэгчийн нэрийг бичих]*** (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Үйлчилгээ” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Үйлчилгээний үнэ нь ***[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]*** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.

2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч ***[Гүйцэтгэгчийн нэрийг бичих]***-ийн харилцах ***[Банкны нэрийг бичих]*** банкны ***[дансны дугаар бичих]*** дугаар дансанд шилжүүлнэ.

3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
    - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
    - 3.2. Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
    - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
    - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
    - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
    - 3.6. Урьдчилгаа төлбөрийн баталгаа;
    - 3.7. Техникийн тодорхойлолт;
    - 3.8. Үйлчилгээ үзүүлэх хуваарь.

4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
    - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл

      Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

| ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| [Албан тушаал, нэр] | [Албан тушаал, нэр] |
| [Гарын үсэг]______________ | [Гарын үсэг] _____________ |
| ТАМГА | ТАМГА |

# ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: ***2024.07.04***
Тендер шалгаруулалтын төрөл: Үйлчилгээ
Тендер шалгаруулалтын нэр: ***Зорчигчдын хоол /Катеринг/***
Тендер шалгаруулалтын дугаар: ***МИАТ/20240103128***
Нийт төсөвт өртөг: ***16,597,655,500***
Тендер шалгаруулалтын арга: Нээлттэй

1. ***МИАТ ТӨХК*** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.

2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: ***"Үгүй"***

3. Тендерийг ***2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 09 цаг 00 минут***–аас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг ***2024 оны 07 дугаар сарын 31-ний*** *өдрийн*, ***09 цаг 30 минут*** *–д* нээнэ.

4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: ***"Зөвшөөрөхгүй"***
5. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: ***"Эрхтэй"***
6. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.

7. Тендерийн баталгаа шаардах эсэх: ***"Тийм"*** Тендерийн баталгаа шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичгийн заасан үнийн бүхий тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.

8. Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: ***"Үгүй"***

9. Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: ***"Үгүй"***

10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

***УБ хот ХУД, МИАТ ТӨХК-ийн II дугаар байр***
***Хангамжийн хэлтэс 117 тоот өрөө, мөн www.tender.gov.mn***
***Утас: 70049860***